

Монгол Улсын 21 аймаг, Нийслэл, түүний 9 дүүргийн Засаг даргын тамгын газар (ЗДТГ) Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаад орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд мониторинг хийж байна.

2017 оны 4 дүгээр сард Өвөрхангай, Орхон, Дорнод, Говьсүмбэр, Говь-Алтай, Баянхонгор, Баян-Өлгий, Архангай аймгууд болон Налайх, Багахангай, Багануур, Баянгол дүүргүүдийн Засаг даргын тамгын газар (ЗДТГ)-ууд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллээ 100 хувь ил тод болгожээ. ЗДТГ-уудын нийтэлсэн мэдээллийг Сангийн яамны Төрийн сангийн тухайн сарын дансны хуулгатай харьцуулж үзэв.


АЖИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ҮР ДҮН

Аймаг, Нийслэл, Дүүргийн ЗДТГ-ууд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллээ ил тод болгох байдалд дорвитой ахиц гарахгүй хэвээр байна.

АЙМГУУДЫН ЗДТГ



Аймгуудын хэмжээнд 2017 оны 4 дүгээр сард 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллээ 8 аймгийн ЗДТГ 100 хувь нийтэлсэн нь өмнөх сарын дүнгээс ахиц гараагүй байна (Тайлбар 1-ийг үзнэ үү).



НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДИЙН ЗДТГ



2017 оны 4 дүгээр сард Нийслэл, дүүргийн хэмжээнд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллээ дөрвөн ЗДТГ 100 хувь ил болгож өмнөх сараас нэгээр нэмэгджээ (Тайлбар 1-ийг үзнэ үү).



Дүн мэдээнд хамаарах тайлбар:

Төрийн сангийн гүйлгээнээс ил тод болгосон хувийг үнэлэхдээ зөвхөн тухайн сард хамаарах цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг болон худалдан авалтыг тооцсон болно. Мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий залруулга хийсэн гүйлгээг тоонд оруулсан болно.

АШИГЛАСАН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас
- ЗДТГ-ын цахим хуудас

- ЗДТГ-ын мэдээллийн самбар
- Сангийн яамны Төрийн сангийн дансны хуулга

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн мониторингийн дүнг сар бүр мэдээлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.